



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 27 өдөр

Дугаар №203

Жавхлант

**Хорио цээрийн дэглэмийг, хязгаарлалтын
дэглэмд шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 18 дугаар зүйлийн 18.1, 18.4, 18.5, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.4, 19.2.7, 19.3.4, 20 дугаар зүйлийн 20.1.1-20.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Тус сумын Дэлгэрхаан багийн малчин П.Оюунбатын суурьт гоц халдварт шүлхий өвчин 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 25-6378 тоот шинжилгээний дүнгээр тогтоогдсон 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/181 дугаар захирамжийн хүрээнд холбогдох зааврыг хэрэгжүүлж ажилласаны үр дүнд өвчлөл илрээгүй тул хорио цээрийн дэглэмийг бууруулж 2025 оны 11 дугаар сарын 27-ны өдрөөс хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2.Хязгаарлалтын дэглэмд шилжсэн П.Оюунбатын малд тогтмол үзлэг тандалт хийж Шүлхий өвчинтэй тэмцэх зааврыг хэрэгжүүлж ажиллахыг Эх цаг ХХК-ны малын эмч (Ч.Нацаг)-д үүрэг болгосугай.

3.Шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээний мэдээ тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Г.Шижирбаатар)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР


ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧИЙН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 11 сарын 27

Жавхлант

- Аврагч-2025 тэмцээнд Хар сүлд багийг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж дэд байранд шалгарсан.
- Аймаг сумын Засаг даргын 02 тоот албан даалгавар велжилтийн бэлтгэл байдлыг хангуулах төлөвлөгөө боловсруулан биелэлтийг ханган ажиллаж байна.
- Наран Сүмбэр багийн нутагт гарсан 3 удаагийн хээрийн түймэр унтраах ажлын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан.
- Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Жавхлант багийн баруун хойно 3 га газарт 1000 мод тарьсан.
- Аймгийн Засаг даргын нэрэмжит "Команд штабын сургуулийн" дадлага үзүүлэлтийг амжилттай зохион байгуулалт хангалттай үнэлэгдсэн.
- Тус сумын нутаг "Талын хөндлөн" хэмээх газарт 1939 оны Халх голын дайны үед Оросын нисэх хүчний 150-р Хороо байрлаж, халх голын дайнд түүхэн үүрэг гүйцэтгэсэн билээ Өнөөдөр энэхүү түүхэн ялалтыг дурсаж, "Талын хөндлөн" дахь Зөвлөлтийн дайчдын хөшөөнд ОХУ-ын ЭСЯ-ны цэрэг агаарын цэргийн аташе хошууч генерал Петрунин Павел Владимирович, ОХУ-ын ЭСЯ-ны 2-р нарийн бичгийн дарга Садыков Людмила Рафкатова зочдыг хүлээн авч 2 орны найрсаг харилцааг бэхжүүлэх зорилготой хүндэтгэл үзүүлж цэцэг өргөх ажлын амжилттай зохион байгуулсан.
- Сумын Засаг даргыг шинээр томилогдох 10 сарын 01-нээс 11 сарын сарын 19 өдрийг хүртлэх хугацаанд түр орлон гүйцэтгэгчээр ажилласан.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
ХЯНАСАН ЗАСАГ ДАРГА



Г.ЭНХЗАЯА
Н.ЦОЛМОНБАЯР